

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Э. Пунцаг

**ЗСБНХУ ДАХЬ ЛЕНИНЧ ҮНДЭСНИЙ БОДЛОГЫН ЯЛАЛТ
(ЗСБНХУ БАЙГУУЛАГДСАНЫ 60 ЖИЛД)**

Олон үндэстний зөвлөлт ард түмэн ЗХУ-ын Коммунист нам, Зөвлөлт төрөө улам бүр нягтран хүрээлж, коммунизмыг байгуулахад чиглэсэн хөдөлмөр тэмцлийн гайхамшигт их амжилтаар өөрсдийн өнөр их гэр бүл болох Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс байгуулагдсаны жаран жилийн ойг угтаж байна. ЗСБНХУ-ын 60 жилийн түүх бол нэгэн гэр бүлд багтсан, урьд өмнө хөгжлийн янз бүрийн шатанд байсан зуу гаруй үндэстэн ястан хэрхэн яаж бүрэн тэгш эрхээр хангагдаж, үндэсний болон нийгмийн дарлал, эдийн засаг, соёлын хоцрогдлыг түүхэн богино хугацаанд устган арилгаж хөгжингүй социализмыг бай-гуулсны бодит биелэл юм. Чухам ийм утгаар ЗСБНХУ-ын 60 жилийг хүн төрөлхтний хөгжил дэвшлийн түүхийн аугаа их ололт гэж болно. Ялангуяа Зөвлөлт дорнодын бүгд найрамдах улсууд болон алс умардын үндэстнүүд ЗСБНХУ-ын их гэр бүлд багтаж эдийн засаг соёлынхоо хэт хоцрогдолтой холбогдсон их саад бэрхшээлтэй нөхцөлд социализмыг амжилттай байгуулсан нь гагцхүү ЗХУ-ын Коммунист нам, их лениний интернационалч үндэсний бодлогыг тууштай биелүүлж, дэлхийд эн тэргүүний ЗСБНХУ байгуулсны шууд үр дүн мөн болно.

«Пролетарийн нам, үндэстнүүдийг хооронд нь ойртуулж, улмаар нэгтгэхийг эрмэлзэж байгаа боловч хүч хэрэглэхгүйгээр, харин их үндэстний ажилчин, хөдөлмөрчин олон түмний ах дүүгийн чөлөөт холбоо тогтоож байж л тэр зорилгодоо хүрэхийг хүсэж байна»¹ гэж В.И.Ленин Октябрийн социалист их хувьсгалаас өмнө бичсэн байдаг. Энэ зорилт 1922 онд ЗСБНХУ байгуулагдсанаар Зөвлөлтийн олон үндэстэн ястан өөр хоорондоо ойртож, нэгдэх үйл явцын эх үндэс тавигдав. ЗСБНХУ байгуулагдан амжилттай хөгжин цэцэглэж ирсэн нь В.И.Лениний үндэсний бодлогын аугаа нх ялалт, түүний амьдрах чадалтайн амьд нотолгоо болж байна. ЗХУ-д биелэлээ олсон энэ бодлого ганц зөвлөлт орноор барахгүй олон улсын түүхэн их ач холбогдолтой билээ.

Холбоо бол янз бүрийн үндэстний хөдөлмөрчдийг бүрэн нэгтгэх явдалд шилжих хэлбэр мөн гэж В.И.Ленин үзээд холбоот улсыг сайн дурын үндсэн дээр байгуулах, хамгаалах, хөгжүүлэх бүхий л асуудлыг онолын хувьд боловсруулж практик дээр удирдан биелүүлсэн учир В.И.Ленинийг бид ЗСБНХУ-ыг үндэслэн байгуулагч гэдэг бөгөөд ЗХУ-ын Коммунист намын үндэсний бодлогыг Ленинч үндэсний бодлого гэж зүй ёсоор бахархан нэрлэдэг юм.

ЗСБНХУ-ыг байгуулсан нь үндэсний асуудлын талаархи К. Маркс, Ф. Энгельс нарын ойлгоцыг бүтээлчээр хөгжүүлсэн В.И.Лениний үзэл санаа, үндэсний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмын амьд биелэл боллоо гэж ЗХУКН-ын ТХ-ноос ЗСБНХУ байгуулагдсаны 60 жилийн ойн тухай гаргасан тогтоолд заажээ. «ЗСБНХУ-ыг байгуулсан нь үйл

¹В. И. Ленин. Зохиолууд 24-р боть 57-р тал.

ажиллагааныхаа зарчим, зохион байгуулалтын бүтэц, үзэл суртал, улс төрийн хувьд гүн бат интернационалч бүрэлдэхүүнийхээ хувьд олон үндэстнээс тогтсон лениний большевикуудын намын асар их гавъяа»² гэж уг тогтоолд онцлон тэмдэглэсэн байна.

ЗСБНХУ нь тэгш эрхтэй ард түмнүүдийн жинхэнэ сайн дурын нэгдэл мөн гэдгийг ЗСБН Холбооны Зөвлөлүүдийн анхдугаар их хурлаас Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс байгуулах тухай гаргасан 1922 оны арван хоёрдугаар сарын 30-ны тунхаглалд болон түүнийг холбооны улсуудаас дэмжиж сайшаасан баримт бичгүүдэд бүрэн дүүрэн тусгагдсан байдаг.

ЗСБНХУ нь Орос оронд хүн хүнээ мөлжих ёсыг үүрд таягдан хаяж, аугаа их Октябрийн социалист хувьсгалаар төрсөн Зөвлөлт засгийн бодит дүр төрх мөн бөгөөд хөгжингүй социалист нийгэмд Зөвлөлтийн бүх ард түмний тууштай ойртох, мөн бүх талын хамтын ажиллагааны явцыг нь хурдасгах, социалист үндэстэн бүр цэцэглэн хөгжих таатай нөхцлийг бүрдүүлэн өгсөн юм. Зөвлөлт нийгмийн бүтцэд гарсан асар их өөрчлөлт, Зөвлөлтийн ард түмний ган бат нэгдлийн бэхжилтийг дүгнэж ЗХУКН-ын XXIV их хурлаас тодорхойлохдоо «Манай оронд социалист байгуулалтын жилүүдэд хүмүүсийн түүхэн шинэ нийтлэг-зөвлөлтийн ард түмэн бүрэлдэн тогтлоо»³ гэсэн билээ.

Тэгэхдээ энэхүү шинэ нийтлэг бол аливаа угсаатны бүлэг буюу онцгой үндэстний нийтлэг биш харин нийгмийн интернационалч шинэ нийтлэг юм.⁴ Нийгмийн интернационалч шинэ нийтлэг болох зөвлөлтийн ард түмнээс бүрдэж байгаа ЗСБНХУ-ын өнөр гэр бүлд өнөөдөр холбооны бүгд найрамдах улс 15, автономит бүгд найрамдах улс 20, автономит муж 8, үндэсний тойрог 10 багтдаг юм.

ЗСБНХУ өсөж хөгжиж ирсэн 60 жилийнхээ хугацаанд ард түмнийхээ тусын тулд түүхэнд байгаагүй лут их амжилт олсон юм. 1922 онд ЗСБНХУ дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд ганц хувь эзэлж байсан бол одоо 20 хувийг нь эзлэх болжээ.

Зөвхөн аравдугаар таван жилд нийтдээ 588 миллиард рублийн үндсэн фондыг ашиглалтад оруулж аж үйлдвэрийн 1200 гаруй том газар барьж байгуулжээ. Сүүлийн 10 жилд нэг хүнд ноогдох бодит орлогын хэмжээ бүтэн хагас дахин нэмэгдсэн бол арваннэгдүгээр таван жилд 16-18 хувь нэмэгдэх юм. Аравдугаар таван жилд 50 гаруй сая хүй орон сууцны нөхцлөө сайжруулсан бөгөөд шинэ таван жилд 530-540 сая хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц барихаар төлөвлөж байна. ЗХУ-д орон сууцны талбай 1 млрд хавтгай дөрвөлжин метр хүрснээр хөдөлмөрчдийн орон сууц эдлэх эрхийг үндсэн хуулиар баталгаатай болгож чадсан юм. Орон сууцны хөлс өрхийн жилийн орлогын 3% болж буй нь дэлхийд хамгийн хямд хөлс болно.

Талх, будаа, ургамлын тос, сахар зэрэг олон төрлийн бүтээгдэхүүний үнийг 1955 оноос, мах сүүний үнийг 1962 оноос хойш нэмэгдүүлээгүй хэвээр байлгаж байна. Энэ хугацаанд цалингийн дундаж хэмжээ 75 гаруй хувиар нэмэгджээ. Шатдаг хий, цахилгааны үнэ 30 гаруй жилийн турш өөрчлөгдөөгүй, хотын тээврийн 3 төрлийн хэрэгслийн үнэ нэмэг-дээгүй. Энэ бүхэн бол ард түмний аж байдлын сайн сайхны төлөө үйлчилдэг бодит социализмын дүр төрх мөн. Эдгээр баримт бол социализмын нөхцөл бололцоо шавхагдсан, социализм цаашдаа явцгүй бол-

²«Правда» 21 февраля 1982 г.

³ЗХУКН-ын XXIV их хуралд тавьсан Төв Хорооны тайлан илтгэл. УБ. 1971. 96-р тал.

⁴П. Федосеев. Новая социальная и интернациональная общность-«Правда»1982. IV. 9.

сон, хямралд орсон мэтээр үзэж буй коммунизмын эсрэг хөрөнгөтний суртал нэвтрүүлэгт няцаалт болж байна. Капиталист гүрнүүд хэдэн зуун жилд хөдөлмөрчин ард түмнийхээ төлөө хийгээгүй, хийж ч чадахгүй байсан зүйлийг ЗСБНХУ 60 жилийн дотор биелүүлж, тэгэхдээ уг хугацаанд дайнд 20 сая хүн, 2,6 их наяд (триллион) рублийн гарз хохирлыг дааж давсан зөвлөлтөөс өөр нэг ч улс орныг түүх мэдэхгүй. Энэ бол бодит социализмын хүч чадлыг бүрэн дүүрэн харуулж байна.⁵

ЗСБНХУ-ын үндсэн хуулиар зөвлөлтийн иргэн бүр хөдөлмөрлөх, сурах, амрах зэрэг баталгаатай эрхүүдээр хангагдсан бөгөөд сонгох сонгогдох, үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг нь зөвлөлтийн ард түмний аж амьдралын аль хэзээний хэм хэмжээ болжээ.

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлд 21 нас хүрсэн бүх иргэн сонгогдох эрхтэй тул 1979 онд сонгогдсон депутатуудын 28,3 хувь нь намын гишүүн бус хүн ба гуравны нэг нь буюу 487 нь эмэгтэйчүүд байв. Энэ нь бүх хөрөнгөтөн орны парламентад буй эмэгтэйчүүдийн тооноос давж байна. Одоо бүх шатны Ардын Депутатуудын Зөвлөлүүдэд ажиллаж буй 100 гаруй үндэстний депутатын тоо 2,3 сая байна.⁶

ЗСБНХУ-д сургуулийн хичээлийг 57 хэл дээр зааж байна. ЗХУКН, залуу үеийг тууштай интернационалч үзэл, Зөвлөлтийн ард түмнүүдийн ах дүүгийн найрамдал, үндэстэн хоорондын харилцааг хүндэтгэн, алив үндсэрхэх үзлийн илрэлтэй үл эвлэрэх үзлээр хүмүүжүүлдэг юм.

1977 онд баталсан шинэ үндсэн хуулиар зөвлөлтийн ард иргэдийн эрх, холбооны бүгд найрамдах улсуудын эрхийг нэгэн адил өргөтгөсөн байна. ЗСБНХУ-ын олон үндэстний өв тэгш хөгжлийг харуулах нэг чухал үзүүлэлт бол холбооны бүгд найрамдах улсууд болно.

Энэхүү жижиг өгүүлэлд зөвлөлт бүгд найрамдах улс болгоныг дурдах боломжгүй тул тэднийг төлөөлүүлж зөвхөн Дундад Азийн зарим бүгд найрамдах улс, Зөвлөлт Бүгд Найрамдах Казак улсын жишээ дээр цөөн баримт иш татая. Зөвлөлт Дорнодын бүгд найрамдах улсууд нь эдүгээ тал бүрийн өв тэгш хөгжилтэй эрх төгөлдөр улсууд болон өөрч- лөгдөж Октябрийн хувьсгалаас өмнө ард түмний «гяндан» гэж нэрлэгдэж байсан орос оронд үндэстний районуудыг хөгжлийн хувьд жигдрүүлж чадсаны үрээр одоо үндэстний хоцрогдмол район гэж байхгүй болжээ.

Хувьсгалаас өмнө хоцрогдмол байсан Дундад Азийн бүгд найрамдах улсууд, түүний дотор зөвлөлт Узбек улс түүхэн богино хугацаанд дорно дахины хамгийн тэргүүний улсуудын нэг нь болтлоо хөгжсөн байна. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хэмжээгээр зөвлөлт Узбек улс одоо Иранаас 15 дахин Пакистанаас 35 дахин илүү гарчээ.

Дундад Азид анх удаа Ташкентийн их сургууль 1920 онд В.И.Лениний санаачлагаар байгуулагдсан бол одоо зөвхөн Узбекстанд 43 дээд сургууль байгаа ба түүнд суралцаж байгаа оюутнуудыг хүн амтай нь харьцуулбал Франц, ХБНГУ, Японыхоос давж байна.

250 жилийн өмнө Орост сайн дураараа нэгдсэн Зөвлөлт Казах улс одоо аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр хувьсгалын өмнөх Оросоос бүтэн дөрөв дахин илүү гараад байна. Бүгд Найрамдах улсын эхэн үед ажилчин анги хүн амын дөнгөж 5 хувь болж байсан бол одоо 70 гаруй хувийг эзэлж байна. Казакстаны 82 хотын 65 нь зөвлөлт засгийн жилд байгуулагджээ. Мөн хугацаанд хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 7 дахинаас илүү нэмэгдэж түүхэн богино хугацаанд 25 сая га атар газар эзэмшижээ.

⁵«Заря Востока» 1982. III. 25.

⁶«Известия» 1982. III. 7.

Социализмыг ингэж социалист үндэстэн байгуулна. Социализмын үед үндэстний асуудал өөр агуулгатай болж ирдэг. Тухайлбал ЗСБНХУ-д үндэстний асуудлыг шийдвэрлэхдээ үндэстний талаар явуулах бодлогыг ЗХУ-д социализм байгуулах ерөнхий зорилтын нэг салшгүй хэсэг болгож тавьсны дүнд Зөвлөлт Дорнодын бүгд найрамдах улсууд түүний дотор урьд хоцрогдсон Азийн бага буурай Киргиз улс өнөөдөр орчин үеийн хүнд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрийн үеийн өндөр хэмжээний эрдэм соёлтой болсон туршлага харуулж байна. 1980 онд Киргиз улсад 3700 нэр төрлийн бүтээгдэхүүн гаргадаг 130 салбартай аж үйлдвэрийн томоохон газрууд 405 ажиллаж байсны дотор өнгөт металл, суурь машины үйлдвэр, электрон ба цахилгаан техник, багаж хэрэгсэл болон автомашин үйлдвэрлэх завод, хөнгөн хүнсний үйлдвэрүүд багтаж байна. Тэдгээрийн бүтээгдэхүүн гадаадын 60 шахам оронд гарч байна. Нэг хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээр Киргиз улс Ази, Америкийн 10 гаруй хөрөнгөтөн орноос түрүүлж яваа хирнээ шинэ арваннэгдүгээр таван жилд Курпсайн усан цахилгаан станцыг барьж дуусгаад Таш-Кумырын усан цахилгаан станцыг ашиглалтанд оруулна.

20-иод оны босгон дээр Киргизын 90 гаруй хувь нь бичиг үсэг үл мэдэгчид байсан бол одоо бүгд найрамдах улсын хэмжээгээр гурван хүнээс нэг нь дээд, дунд буюу тусгай мэргэжлийн аль нэгэн сургуульд суралцаж байна. Нэг үгээр хэлэхэд эртний Киргиз нутаг дээр одор л социалист шинэ залуу Киргиз улс мандан цэцэглэж ах дүү ард түмний эвдэршгүй найрамдал хамтын нөхөрлөлийн яруу сайхан жишээ болж байна. Киргиз нь автономит муж (1924 он)-аас автономит бүгд найрамдах улс (1926 он), дараа нь холбооны бүгд найрамдах улс (1936 он) болсон түүхтэй. Энэ бол хоцрогдсон ард түмэн орчин үеийн хөгжлийг гүйцэж ирэхтэйгээ зэрэг үндэстний хоорондох эдийн засаг, соёлын ялгаа эрс багасдаг учраас үндэстний ойртох, нийлэх явцыг харин ч хурдасгаж цаашдаа социализм коммунизмд нэгэн зэрэг дэвшин орох нөхцөл бүрдүүлдэг зүй тогтолтойг харуулж байна.

Саяхан хүртэл өөрийн бичиг үсэггүй, зарим эрдэмтдийн тооцсоноор хүн амыг нь бичиг үсэгт сургахад хэдэн зуун жил хэрэгтэй гэж байсан Киргизстанд бичиг үсэг үл мэдэх явдлыг хэдхэн арван жилийн дотор устгаж бичигтний хувьд бүр дэлхийн II дайнаас өмнө зөвлөлтийн нийт үндэстнүүд зэрэгцэж тэгширсэн юм.

Зөвлөлт засгийн жилүүдэд холбооны улсууд нь зөвхөн эдийн засгийн хувьд биш бас соёлын хувьд жигдэрсэн нь зөвлөлтийн ард түмэн улмаар материаллаг ба оюун санааны хувьд жигдрэх үйл явцыг хурдасгажээ. Энэ үйл явцын цаашдын төлөвийн талаар ЗХУКН-ын XXVI их хурлаас заахдаа «Үндэстний соёл цэцэглэн бие биеэ баяжуулж, нийгмийн интернационалч шинэ нийтлэг болсон нэгдмэл зөвлөлтийн ард түмний соёл бүрэлдэн төлөвшиж байна»⁷ гэсэн билээ. Нийгэм эдийн засгийн ийм гүн гүнзгий өөрчлөлтийг холбооны аль ч бүгд найрамдах улсаас харж болно. Харин үндэстэн, ард түмний бодит тэгш байдлыг хангах үүднээс бүгд найрамдах улсуудын эдийн засгийн хөгжлийн түвшинг цаашид жигдрүүлэх бодлого явуулдаг юм. Үүний жишээ нь арван нэгдүгээр таван жилд хэрэв ЗСБНХУ-ын хэмжээгээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг 26-28 хувиар нэмэгдүүлэх бол холбооны улсуудад 28-32 хувиар нэмэгдүүлэхээр заажээ.⁸

⁷Л. И. Брежнев. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод гадаад бодлогын ээлжит зорилт. УБ, 1981. 93-р тал.

⁸ЗХУКН-ын XXVI их хурал. ЗСБНХУ-ын эдийн засаг, нийгмийг 1981-- 1985 онд болон 1990 он хүртлэх хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл, бусад баримт бичиг. УБ. 1981. 73-р тал.

Социалист эдийн засгийн ийм бодлого бол ЗСБНХУ-ын нийтлэг эрх ашиг холбооны бүгд найрамдах улс тус бүрийн эрх ашгийг жигд хослуулах тэдгээрийн аж ахуйг тэнцвэрт харьцаатайгаар өрнүүлэх, Зөвлөлтийн нийгэм-эдийн засгийн амьдралыг интернационалчлах явцыг уялдуулах замаар хэрэгжүүлэхэд чиглэгдсэн чухал арга хэмжээ юм. Энэ талаар ЗСБНХУ нь эрх чөлөөг, эрх төгөлдөр бүгд найрамдах улсуудын төрийн хамгийн боломжтой хэлбэр болохыг, туршлага харууллаа. ЗХУ-д нийгмийн гишүүдээс үйлдвэрлэлийн багаж зэвсэгтэй харилцах талаар нэг төрөл болох явдал өсөн нэмэгдсээр байна. Үүнд ЗСБНХУ-ын бүх хүн амын тавны дөрвөн хувь нь дан ганц бүх ард түмний өмчтэй, тавны нэг хувь нь хамтралын өмчтэй тус тус ажил хөдөлмөрөөрөө холбогдож байна.⁹ Ингэж нийгмийн талаар нэг төрөл болох нь зөвхөн хөгжингүй социализмын үед байдаг чанарын шинэ онцлох шинж юм.

Нийгэм эдийн засгийн хувьд хоцрогдсон орон, ард түмэн тэргүүний орны ард түмний тусламжтайгаар хөгжлийн капиталист шатыг алгасч коммунизмд шилжиж болох тухай К. Маркс, Ф. Энгельс нараас онолын хувьд дэвшүүлсэн капиталист бус хөгжлийн тухай сургаалыг В.И.Ленин социалист хувьсгалын үед хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлыг бо-ловсруулсан нь түүнээс үндэстний ба үндэсний колоничлолын асуудлын марксист онолд оруулсан гайхамшигт хувь нэмэр болой. Энэхүү нарийн авцалдаатай сургаалын бүрэн амьдрах чадалтайг Зөвлөлт Дорнодын бүгд найрамдах улсууд болон Зөвлөлт Казакстаны туулж ирсэн түүхэн замнал нотолж байна.

ЗСБНХУ-д үндэстний асуудлыг ингэж зөв зүйтэй шийдвэрлэсэн ба шийдвэрлэж байгаа туршлага бол олон улсын онол практикийн ач холбогдолтойг дэлхий дахины улс түмэн, тэр ч байтугай Зөвлөлт улсын дайсан нь хүртэл хүлээн зөвшөөрч байгаа билээ. Социалист хувьсгал хийж шинэ нийгэм байгуулахын нэг чухал зорилтын хувьд үндэстний асуудлыг шийдвэрлэх Зөвлөлтийн туршлага бол түүхэнд давтагдах, тэгэхдээ хуулбарлагдах биш, гол зүйл нь давтагдах ёстой зүйл юм.

Ийм зүй тогтлын үүднээс бид Бүгд Найрамдах Хятад Ард улс дахь үндэстний асуудлын өнөөгийн төлөвийг цухас авч үзье. БНХАУ бол Зөвлөлт Холбоот улстай хил залгаа оршдог хөрш, мөн олон үндэстэн, ястны улс бөгөөд, гэтэл үндэстний асуудлыг шийдвэрлэх талаар энэ хоёр улс өдөр, шөнө шиг ялгаатай байна.

ХКН үндэстний асуудалд эхэн үедээ нэлээд нааштай хандаж байсан тал бий.¹⁰ Энэ бол хятадын интернационалчдын оруулсан хувь нэмэр бөгөөд түүний бнд хүндэтгэн үзэж дурсан санаж байна.

Намын II, III, VI, VII их хурлуудын баримт бичгүүд, тэрчлэн 30-аад оны эхээр хуралдсан бүх хятадын зөвлөлүүдийн I, II их хурлаас үндэсний асуудлаар гаргасан тогтоолд Холбоот улс байгуулах, тэгэхдээ хятад бус үндэстнүүдийн салан тусгаарлах хүртэл өөртөө засах эрхийг хүлээн зөвшөөрөх зэрэг чухал заалтууд оруулж байжээ. Гэвч ХКН-ын доторхи үндэсний үзэлтнүүд, тухайлбал, «зүүний нугалаатан» гэгчийн толгойлогч Ли Лисань, 1930 оны 8-р сарын 1-нд ХКН-ын ТХ-ны Улс Төрийн товчооны хуралд оруулсан төлөвлөгөөндөө Хятадад бослого амжилттай болмогц Монголыг Хятадын холбоот улсад нийлүүлэх тухай

⁹Ф. Филиппов, А. Фриш. Социальная структура зрелого социалистического общества: Изучение тенденций развития—жур: «Общественные науки» М. 1981 № 6. с 13.

¹⁰Л. М. Гудошников. Политический механизм Китайской народной республики. М. 1979. с 30.

санал дэвшүүлж байсан¹¹ бол Мао Зэдун 1936 онд америкийн сэтгүүлч Эдгар Сноутай ярилцахдаа хятадын хувьсгал ялахтай хамт БНМАУ аяндаа хятадын холбооны хэсэг болно гэж мэдэгджээ.¹² Үүнээс үзэхэд ХКН-ын доторхи үндэсний үзэлтнүүд монгол, төвд, хотон зэрэг хятад бус үндэстнүүдийн тусгаар тогтнох хүртэл эрхийг хүлээн зөвшөөрдөггүй байсан төдийгүй мөн аль түрүүнд тусгаар тогтносон (1921) бүрэн эрхт БНМАУ-ыг хүртэл өөртөө нэгтгэж авахыг урьдал болгож байсан нь илэрхий ажээ.

Орчин үед их хятадын дээрэнгүй үзэл улам гаарч хэрэг дээрээ ХКН-ын үндэсний бодлогын эх уурхай нь болж байгаа учраас маоист түүхчид хятадын их гүрний жанжлах бодлогыг онолын үүднээс ул үндэстэй болгох гэж оролдохдоо Хятад болон хятад бус ард түмний түүхийг зориуд гуйвуулж, түүнийг хятадын өнөөгийн эрх баригчдын шүтэж байгаа их гүрний жанжлах үзэлд захируулж байна.

Өрнөдийн зөвлөлтийг судлаачид ЗСБНХУ-ыг байгуулагдсан цагаас нь эхлэн муулсан бөгөөд одоо ч гэсэн Америкийн түүхч Пайпс, профессор Донелли нарын маягийн хөрөнгөтний үзэлтнүүдийн бичсэн зүйлд «зөвлөлтийн колоничлох бодлого», «зөвлөлтийн колоничлолын эзэнт улс»¹³ гэх мэт нэр томъёо салахгүй байна. Тэд коммунизмын эсрэг үз-лийн үүднээс шинэ колоничлолыг хамгаалж «гуравдахь ертөнцийн» хөгжиж байгаа орнуудад Дундад Азийн Зөвлөлт бүгд найрамдах улсуудын социалист хөгжлийн түүхэн замналыг муулахыг мэрийдэг байна. Английн хөрөнгөтний нэрт түүхч Арнольд Тойнби¹⁴ бүрч хэтэрч оросын пролетари нар шашин шүтлэг өөртэй Ази, Африкийн ард түмэнтэй хол- боо тогтоож чадахгүй гэж айлддаг байна. Үүний хамтад өнөөгийн маоист түүхчид Дундад Азийн бүгд найрамдах социалист улсууд, мөн БНМАУ-ын капиталист бус хөгжлийн түүхэн туршлага, Ази, Африкийн олон орны социалист чиг баримжааг өрнөдийн түүхчидтэй хоолой хоршин өширхөн муучлах болсон нь хятадын эрх баригчдын социализмын эсрэг, зөв- лөлтийн эсрэг үзлийн нь тод илрэл мөн.

Хятадын удирдагчид үндэстнүүд ойртон нягтрах тухай жинхэнэ марксист-ленинист сургаалыг элдвээр мушгин гуйвуулж ЗХУ-д үндэстний ялгааг хүчээр үгүйсгэж бангаа мэтээр гүжирдэж «үндэстнийг ойртуулах» гэдэг малгайны дор тэд (ЗХУ-д) орос бус үндэстнийг «оросчлох» цагаан хааны үеийн их оросын уусгах үзэл, үндэстний дарлал явуулж байна гэж¹⁵ үзэж байгаагаар хөрөнгөтний онолчдын хамгийн харгис баримтлалыг звэлдэж буй хэрэг билээ.

Маоизмын үндэсний бодлогын баримтлалаас хийж болох өөр нэг дүгнэлт бол «Мао Зэдун хятадын нөхцөлд үндэстний асуудлыг шийдвэрлэхэд тохирох адив нааштай программ дэвшүүлж чадах ч үгүй байв. Яагаад гэвэл тэрээр үндэстний асуудлыг шийдвэрлэх марксист-ленинист сургаалаас урван тэрсэлж, социалист орнуудад үндэстний асуудлыг шийдвэрлэх

¹¹А. М. Григорьев. Борьба под лозунгом советов в Китае в кн: Коминтерн и Восток. М. 1969. с 331.

¹²Ю. Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ. 1976. 654—655-р тал.

¹³И. С. Зенушкина. Советская национальная полигика и буржуазные историки. М. 1971. с 260.

Michael Rywkin: "Russia in Central Asia", N. Y. 1963. p. 159. Villiam O. McCag and others. "Soviet Asian Ethnic Frontiers" N. Y, 1981—"Far Eastern Economic Review", Dec. 18—24, 1981.

¹⁴Ленинизм и национальный вопрос в современных условиях. Издание П. М. 1974. с 585.

¹⁵«Жэньминь жибао» 1974. V. 1.

түүхэн туршлага, түүний дотор ЗХУ-ын туршлагыг эн тэргүүнд элдвээр үгүйсгэх буюу гутаахыг оролдсоор иржээ»¹⁶ Гэтэл Хятадад хувьсгал ялах үед ЗСБНХУ нь олон үндэстний социалист улсын сонгодог үлгэр жишээ болж чадсан бөгөөд нийгэм, эдийн засаг, угсаа-соёлын нөхцлийн хувьд Орос орны хуучин байдалтай зарим талаар төстэй Хятад оронд ЗСБНХУ-ын баялаг туршлагыг бүтээлчээр хэрэглэх явдал хичнээн чухал ач холбогдолтой байсан нь мэдээж юм.¹⁷ Асуудалд хэрэв учиртай хандвал өөрөөр хэлбэл, үндэстний асуудлыг шийдвэрлэх маркоист-ленинист зарчмаас хятадын эрх баригчид ухраагүйсэн бол 30 гаруй жилийнхээ хөгжилтөд Хятадын үндэстэн ястнууд багагүй амжилт олж болох байсан нь эргэлзээгүй. Үүнтэй холбогдуулж хятадын эрх баригчдаас «суугуул» нутгаа гэж ярих дуртай Зөвлөлт Киргиз улстай хил зэргэлдээ орших Хятадын Синьзян Уйтарын Автономит Район (СУАР)-ыг авч үзье. Нэрээс нь аваад үзсэн ч нэг нь улс, нөгөө нь район болох нь тодорхой. 1949 онд Хятадад хувьсгал ялснаар Синьяаны ард түмэн гэрэлт ирээдүйтэйгээ золголоо гэж найдсан боловч тэр найдлага өнөө хүртэл биелэгдээгүй нь харамсалтай. 10 гаруй ястнаас бүрэлдсэн 11 сая хүн ам оршин суугаа энэ автономит районоос зөвхөн автономит хэмээх нэр л үлдээд байна.

1978 оны шинэ үндсэн хууль, үндэстний бодлогыг гуйвуулж байсан гэгч Лин Бяо «дөрвийн бүлэг»-ийг 1980 онд шүүсэн аль аль нь байдлыг өөрчилсөнгүй ажээ. Энд хилийн район гэдэг нэрийдлээр хүчтэй цэрэгжүүлэлт явж уйгар, казак, монголчуудын суугуул нутаг нь хятадаар дүүрч хэрэг дээрээ хятад хүн «эзэн сууж эрх барьсаар» байгаа нь их хан үндэстний дээрэнгүй үзэл ноёрхон, хятад бус үндэстнүүд түүний бай болсоор буйн тэмдэг юм. СУАР-ны Ардын Төлөөлөгчдийн Хурлын байнгын хорооны 14 орлогчийн тэн хагас нь хан үндэстэн (хятад) байна.¹⁸

Өвөр Монгол, Төвдөд хүчээр уусгалт улам ирмүүн хүчтэй явагдаж байна. Жилд 50-60 мянган хягад иргэд ирж суурьших учир одоогийн байдлаар Өвөр Монголд хүн амын 92% нь хятад, 8% нь монгол болжээ. Гучаад жилийн өмнө хятад хүн бараг үзэгдэхгүй байсан Төвдийн Лхас хотод одоо хятадууд хүн амын 58,5% нь болсон жишээтэй байна. Хятад дахь хятад бус олон үндэстэн ястны бичиг соёлын түвшин нэн дорой байгаа юм. Хятадын 50 гаруй цөөнх үндэстний дөрөвний гурав нь буюу бараг 40 шахам нь одоо хүртэл бичиг үсэггүй байна.¹⁹ Энэ нь БНХАУ-ын хэмжээгээр бичиг үл мэдэгч 150 сая хүний бараг гуравны хоёрыг хятад бус үндэстэн эзэлж буйг харуулж байна.

Хятадын удирдагчид үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмын гол үндсүүдийг хятадын «өвөрмөц» байдал гэдэгт үл тохирох нэрийдлээр тухайн үедээ төлөвлөгдөж байсан хятадын холбоот улсын тухай лоозонг биелүүлээгүй билээ. Үндэстний өөртөө засах эрх ийнхүү Хятадад БНХАУ байгуулагдахаас өмнө ч «тохирохгүй» байсан, 1949 онд БНХАУ байгуулах үед ч «тохироогүй»-гээс гадна хятадын өнөөгийн

¹⁶Ш. Бира. Маоизм и национальный вопрое в КНР-в кн: Маоизм и национальный вопрос» (Материалны международного научного симпозиума) УБ. 1980. с 23.

¹⁷Мөн тэнд. 22-р тал.

¹⁸Т. Р. Рахимов. Судьбы неханьских народов в КНР. М. 1981. с 144

¹⁹А. А. Москалев. Политика КНР в национально-языковом вопросе. М. 1981. с32.

нөхцөлд ч «тохирохгүй» байгааг Жоу Эн-лайн хэлсэн үг²⁰ харуулж байна.

Хувьсгалын социалист шатанд үндэстний асуудал хувьсгалын ардчилсан буюу эхэн шатных шиг улс орноо чөлөөлөх эрх ашигт захирагддаг шинж нь аяндаа өөрчлөгдөж ирдэг байна. Шинэ шатанд үндэстний асуудал хэрэв ноёрхогч үндэстний эрх ашигт захирагдах шинжтэй байвал тэр нь захирагддаг үндэстэн буйн шинж болно. Ийм нөхцөлд ард түмэн өөртөө засан тохинох бүрэн эрхийнхээ төлөө тэмцлээ үргэлжлүүлнэ. БНХАУ-ын хятад бус ард түмний хувьд байдал яг иймэрхүү байгаа юм. Одоогийн Хятад улсад үндэстний асуудлыг шийдвэрлэх марксист-ленинист интернационалч зарчмыг их хан үндэстний дээрэнгүй үзэл гол сүнс нь болсон маоизмын үндсэрхэх үзлээр, үндэстний өөртөө засан тохинох эрхийг нь хятадын орон нутгийн автономит буюу өөртөө засахаар тус тус сольж хязгаарлаад байна. Ингэснээрээ хятадын маоист удирдагчид зөвхөн үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмаас төдий бус марксизм, ленинизмаас бүхэлд нь урван тэрсэлснээ харуулж буй хэрэг. Үүний уршгаар Хятад дахь үндэстнүүд хоорондоо «үндэстний бүлгэмдэл»-тэй биш, харин зөрчилтэй байгаа нь хар хүчээр уусгах замаар үндэстний асуудлыг шийдвэрлэх бодлого хэзээ ч амжилтанд хүрч байгаагүйг харуулж байна. «Соёлын хувьсгалын» үед улаан нүүрээ харуулсан Маогийн үндэстний бодлогыг далаад оны сүүлчээс эхлэн «засварлах» бодлогод шилжсэн боловч маоизмыг хичнээн ч гоёж чимээд Хятад дахь үндэстний асуудлыг шийдвэрлэж чадахгүй нь илэрхий юм.

Харин хүн төрөлхтний түүхэнд үндэстний асуудлыг зөв шийдвэрлэх ганц зөв мэргэн арга бол марксист-ленинист үндэстний бодлого мөн болохыг түүх харуулав. Энэ аргыг зөв хэрэглэвэл чухам ямар амжилтанд хүргэдгийг зөвлөлтийн туршлага, түүнээс ухарвал ямар аюулд хүргэдгийг хятадын «туршлага» харууллаа. Сайн, муу хоёр ийм түүхэн сургамж байна. Дэлхий дахины олон тооны тууштай интернационалч коммунистууд үндэстний асуудлыг шийдвэрлэхэд социализмын давуу талыг зөвшөөрөн хүлээхийн хамт үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмаас ухрах явдлыг илрүүлэн шүүмжилсээр ирсэн юм.

Социализмын уг чанарт харш шовинизм буюу үндсэрхэг үзлийн аль алиний нь эсрэг ЗХУКН тууштай тэмцэхийн хамт мөн үндэстний онцлогийг зориуд баллаж арилгах оролдлого эсвэл үндэстний онцлогийг зориуд хөөргөж дөвийлгөх явдлын аль алинийг нь бодит социализмын үеийн үндэстэн ястны нөхөрлөл, нягтралд харш зүйл гэж үзсээр иржээ.²¹

Хятадын ард түмэн их хан үндэстний дээрэнгүй үзлийн хүнд хүчир сорилт бэрхшээлийг туулж байгаа энэ хүнд үед ЗХУ-ын коммунист нам, ЗСБНХУ-ын засгийн газар анх байгуулагдаж байсан 60 жилийн өмнөхтэйгээ нэгэн адил өнөөдөр ч гэсэн интернационалч халуун сэтгэл гаргаж хоёр улсын харилцааг сайжруулах чухал санаачлага гаргасаар байна.

Хятадын удирдагчдын бодлогын социалист орнуудын хоорондох харилцаанд байж үл болох харш бодлогыг А. И. Брежнев бүр арваад жилийн өмнө цохон тэмдэглээд «Хятадыг цэцэглэн байгаа социалист гүрэн байж, түүнтэй хамт империализмын эсрэг, энх тайвны төлөө тэмцэхийг эрмэлзэж буйг²² илэрхийлсэн бол энэ оны 3-р сард Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбек улсад Лениний одон гардуулахад зориулан Таш-

²⁰Жоу Энлай. 1957 оны 8-р сарын 4-нд үндэстний асуудлаар хийсэн бүх хятадын зөвлөлгөөнд хэлсэн үг. «Жэньминь жибао» 1979. XII. 31.

²¹Л. И. Брежнев. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод гадаад бодлогын ээлжит зорилт. УБ 1981. 92-р тал.

²²Л. И. Брежнев. О пятидесятилетии Союза Советских Социалистических республик. (доклад) «Правда» 1972. XII. 22.

кент хотноо хийсэн баярын хурал дээр хэлсэн үгэндээ «Хятадын нийгмийн социалист байгууллыг» үнэлж зөвлөлт, хятадын харилцааг сайжруулах талаар хэлэлцвэл тохиролцох саналыг дахин дэвшүүлжээ.²³ Энэ бол ЗСБНХУ 60 жилийнхээ ойн босгон дээр дэвшүүлэн тавьж байгаа эрхэм ухаалаг бөгөөд хүнлэг хандлага, үнэт санаачлага, ЗХУКН-ын тууштай интернационалч гадаад бодлогын бас нэг тод илрэл мөн.

ТОРЖЕСТВО ЛЕНИНСКОЙ НАЦИОНАЛЬНОЙ ПОЛИТИКИ В СССР (60-ЛЕТИЮ СССР).

Э. Пупцаг

Резюме

Победа ленинской национальной политики в СССР-это величайшее достижение в истории социального развития человечества. Автор статьи характеризует Союз Советских Социалистических Республик как качественно новую форму единения суверенных государств, в условиях реального социализма. Образование СССР является торжеством ленинской национальной политики. Оно дало возможность ранее отсталым народам Советского Востока перейти к социализму, минуя целую эпоху общественного развития-эпоху капитализма.

Приводя конкретные данные, автор отмечает, что советские республики Средней Азии и Казахстан превратились в современные высокоразвитые государства на Востоке, а народы их стали равноправными членами великой семьи советского народа. Советский народ-новая историческая, социальная и интернациональная общность людей, что представляет собою совершенно новое явление в истории народов.

Опыт СССР ярко подтверждает, что только социалистическая революция обеспечивает подлинное равноправие, единение всех наций и народностей, только она в сила разрешить национальный вопрос в свете учения В.И.Ленина, как составной части строительства социализма ного вопроса, подтвержденного практикой зрелого социализма в СССР- есть явление повторимое для народов Азии, Африки и Латинской Америки, перед которыми стоят многие задачи решения национального вопроса

В то же время в КНР в результате отказа маоистов от марксистско-ленинского учения по национальному вопросу, игнорирования всемирноисторического опыта СССР проводится политика насильственной ассимиляции неханьских народов, территории которых занимают 60% всего Китая. Отказ от признания за некитайскими народами права на самоопределение-пишет автор-явился открытым выражением великоханьского шовинизма. Автором приводятся конкретные данные относительно тяжелого положения в национальных автономных районах КНР. Практика создания местной автономии в КНР показала суть маоистской национальной политики, исключавшей подлинное равноправие народов различных народностей и народов в условиях многонационального государства.

В заключение автор подчеркивает, что СССР и КНР представляют собою два контрастных примера решения национального вопроса в современную эпоху.

²³ «Үнэн» 1982. III. 26.